




УЛСЫН ГАЗАРЗҮЙН 29-Р ОЛИМПИАД

9 дүгээр анги



1. Уур амьсгалын өөрчлөлт (Нийт 6 оноо).

Зургийг ажиглан асуултад харнулаарай.



А. Зураг ямар үйл явцыг илэрхийлж байна вэ? Нэрлэнэ үү (1 оноо).

В. Тоогоор тэмдэглэсэн хэсэг тус бүрт ямар үйл явц явагдаж байгааг товч тайлбарлаж бичнэ үү (4 оноо).

С. Үсгээр тэмдэглэсэн хэсгийг нөхөж бичнэ үү (1 оноо).

2. Цаг агаарын тогтолцоо ба агаар мандлын үйл явц (Нийт 6 оноо)

Агаар мандлын загварчлалын тусламжтайгаар Улаанбаатар хотын уртрагийн 106.85° дагуу өргөргийн 47.77°- 48.05° хооронд зүсэлт хийжээ. Хүснэгтийг ашиглан дараах даалгаврыг гүйцэтгээрэй.

Уртраг, градус	Өргөрөг, градус	Өндөр, м	Салхины хурд, м/с	Температурын инверсийн эрчимшил, °C
106.85	47.77	1530	3.0	4.2
106.85	47.80	1655	3.3	3.9
106.85	47.85	1559	2.6	4.4
106.85	47.87	1427	2.2	4.8
106.85	47.88	1342	2.1	4.9
106.85	47.88	1290	2.2	5.0
106.85	47.91	1282	1.9	4.9
106.85	47.94	1431	2.5	4.5
106.85	47.96	1471	2.6	4.4
106.85	48.00	1674	3.0	4.0
106.85	48.02	1767	3.2	3.6
106.85	48.05	1681	3.0	3.6

А. 106.85° уртрагийн дагуух инверсийн график байгуулна уу (4 оноо).

В. Графикт үндэслээд температурын инверсийн давхаргын эрчимшил, далайн түвшнээс дээших өндөртэй (рельеф) ямар хамааралтай байгааг тайлбарлаарай (2 оноо).

3. Гадарга ба геоморфологи (6 оноо)

Монгол Алтайн нурууны Алтай таван богд уул орчимд 10 гаруй мөсөн гол байдгийн нэгийг нь алдарт аялагч П.К.Козловын нэрээр нэрлэсэн байдаг. Дараах мөсөн голын зургийг ажиглан асуултад хариулаарай.




А. 1906 ба 2003 оны Козловын мөсөн голын хэмжээнд ямар өөрчлөлт гарсан байна вэ? Нөлөөлсөн үндсэн 2 шалтгааныг тайлбарлана уу? (2 оноо)

В. Мөсөн гол хайлах үйл явцад үүссэн гол, пуга, мөстлөгийн морен зэрэг тогтоц хэрхэн өөрчлөгдсөн байж болох вэ? (3 оноо)

С. Тухайн бүс нутагт сүүлийн 100 гаруй жилийн хугацаанд хур тунадасны хэмжээ хэрхэн өөрчлөгдсөн байж болох вэ? (1 оноо)

4. Ус судлал ба усны менежмент (4 оноо)

Зургийг ажиглаад асуултад хариулаарай.



А. Ногоон шугамаар юуг дүрсэлсэн бэ? (1 оноо)


В. Гурвалжин тэмдгээр ус судлалын харуулын байршлыг тэмдэглэсэн ба Хэрлэн гол дагуух усны харуулын байршлын шалтгааныг тайлбарлаарай (2 оноо).

С. Одоогоор Монгол оронд 150 орчим усны харуул ажиллаж байна. Дэлхийн цаг уурын байгууллагаас дунджаар 1500 км^2 талбайд 1 усны харуул байхыг шаарддаг бол Монгол оронд ойролцоогоор хэдэн усны харуул шаардлагатай вэ? Гарсан үр дүнд та ямар дүгнэлт өгөх вэ? (1 оноо)

5. Нөөцийн менежмент (7 оноо)



2020 онд Нил мөрөн үсрлэж эрэг дагуух Судан улсын хот, суурин газрууд их хэмжээний хохирол амссан. Харин Египет улс энэ үерээр хохирол бага байснаас гадна эдийн засагт нь эсрэгээр нөлөөлсөн гэж үзжээ. Зургийг ашиглан дараах даалгаврыг гүйцэтгээрэй.



A. Зураг дээрх А,В,С газарзүйн объектуудыг нэрлэж бичээрэй (3 оноо).

- A.
- B.
- C.

B. Нил мөрний усыг ашиглан хийгдсэн дэлхий алдартай томоохон бүтээн байгуулалтыг нэрлээрэй (1 оноо).

C. Уг бүтээн байгуулалт Египет улсын эдийн засагт эсрэг нөлөө үзүүлсэн 2 жишээг тайлбарлаж бичээрэй (2 оноо).

D. Дээрх бүтээн байгуулалтаас үүссэн сөрөг нөлөө үзүүлсэн 2 жишээ бичээрэй (1 оноо).

6. Эдийн засгийн газарзүй ба даяарчлал (Нийт 6 оноо)

Монгол улсад 15-аас дээш насны ажил эрхлэгсдийг аж үйлдвэрийн салбараар ангилсан мэдээллийг хүснэгтэд өгчээ.

д/д	Он	2019	2023
	Бүгд /мянган хүн/	1146.2	1215.8
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт ан агнуур	290.2	293.8
2	Уул уурхай, олборлолт	57.9	67.2
3	Боловсруулах үйлдвэр	90.4	109.1
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	19.3	21.5
5	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	10.8	10.5
6	Барилга	68.8	79.8
7	Бөөний болон жижиглэн худалдаа; автомашин, мотоциклын засвар үйлчилгээ	160.4	163.7
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	61.1	69.2
9	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	36.3	33.4
10	Мэдээлэл, холбоо	13.0	17.5
11	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	24.3	20.4
12	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1.2	1.6
13	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	18.0	17.7
14	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	20.2	14.6
15	Төрийн удирдлага ба баглан хамгаалах үйл ажиллагаа албан журмын нийгмийн хамгаалал	86.0	75.8
16	Боловсрол	96.1	123.9
17	Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	44.4	52.8
18	Урлаг, үзвэр, тоглоом наадм	18.0	9.3
19	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	24.5	31.8
20	Хүн хөдлөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	3.3	1.2
21	Олон улсын байгууллага, суурийн толоологчийн үйл ажиллагаа	2.0	1.0

А. Эдийн засгийн салбаруудыг хамрагдах ангилалд хүснэгтэд өмнөх дугаараар нь ангилна уу (2 оноо).

Эдийн засгийн салбар	Харгалзах дугаар
Анхдагч	
Хоёрдогч	
Гуравдагч	
Дөрөвдөгч	

В. Анхдагч, хоёрдогч, гуравдагч, дөрөвдөгч салбар болгон ангилж хувийг олоорой (2 оноо).

	2019	2023
Анхдагч салбар		
Хоёрдогч салбар		
Гуравдагч салбар		
Дөрөвдөгч салбар		


С. 2019 ба 2023 онуудад аж үйлдвэрийн салбарт ямар өөрчлөлт гарсныг дүгнэж 4 үндэслэл бич (2 оноо).

7. Хотын газарзүй, хотын өөрчлөлт, төлөвлөлт (Нийт 3 оноо)

А хотын суурьшлын цаг хугацааны өөрчлөлтийг ажиглаад 2030 онд яаж өөрчлөгдөхийг таамаглан зурна уу.




2015 оны суурьшил



Таних тэмдэг

■ Суурьшил бүхий нутаг дэвсгэр


2020 оны суурьшил



Таних тэмдэг

■ Суурьшил бүхий нутаг дэвсгэр


2025 оны суурьшил



Таних тэмдэг

■ Суурьшил бүхий нутаг дэвсгэр

2030 оны суурьшил



Таних тэмдэг

■ Суурьшил бүхий нутаг дэвсгэр

8. Соёлын газарзүй, бүс нутгийн онцлог (Нийт 4 оноо)




А. Дараах соёлын хэв шинжүүдийг ямар улсад хамааралтай болохыг бичнэ үү (2 оноо).

Соёл, Улс	газарзүйн хэв шинж	Газарзүйн онцлог	Онцлог шинж	Соёлын хэв шинж	Бодит жишээ
1		Галт уул	Өндөр хөгжил	Цайны ёслол	Халуун рашаан
2		Хуурай уур амьсгал	Нэгдмэл улс	Хүн толгойт арслан сфинкс	Услалтын систем
3		Тропикийн муссон	Кастын систем	Олон хэлээр ярьдаг	Аутсорсинг
4		Уулархаг	Хувь хүний бие даасан байдал	Франц, Герман, Итали хэлээр ярьдаг	Шоколад, цаг

В. 1 дугаартай улсын газарзүйн онцлог ба бодит жишээ хоорондоо хэрхэн хамаарах вэ? (2 оноо)

9. Тээврийн газарзүй (Нийт 8 оноо)

Монгол улс 2025 оныг бүсчилсэн хөгжлийн жил болгон зарласан. Энэ хүрээнд авто зам, төмөр замын тээврийг хөгжүүлэхээр төлөвлөсөн.



А. Эдгээр төлөвлөсөн авто ба төмөр замуудыг зурагт тэмдэглээрэй (6 оноо).

- Бага-Илэнх боомт-Хутаг-Өндөр-Булган хот-Хишиг-Өндөр-Элсэн тасархай-Арвай хээр-Гучин-Ус-Гурвантэс-Шивээхүрэн боомт чиглэлийн босоо тэнхлэгийн авто зам.
- Арцсуурь боомт-Баянхайрхан сум-Тэлмэн сум болон Улиастай хот-Алтай хот-Цээл-Бургастай боомт чиглэлийн босоо тэнхлэгийн авто зам
- Булган боомт-Мөст-Хөшөөтийн уурхай-Дарви-Завхан аймгийн Цагаанхайрхан сумд нийлэх чиглэлийн төмөр зам
- Ханх боомт-Хатгал-Алаг-Эрдэнэ-Мөрөн хот-Бүрэнтогтох-Тэлмэн сум чиглэлийн босоо тэнхлэгийн авто зам
- Сүмбэр боомт-Матад-Баруун-Урт-Сайншанд-Зүүнбаян чиглэлийн хэвтээ тэнхлэгийн төмөр зам
- Чингис хот-Чойр хот-Говь-Угтаал сум-Мандалговь хот-Сант сум-Арвайхээр хот чиглэлийн хэвтээ тэнхлэгийн зам

В. Төлөвлөсөн авто замуудыг барьснаар Монгол орны бүс нутаг, эдийн засагт ямар ач холбогдлыг бичгээрэй (2 оноо).